



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2023 СУУРЬ БОЛОВСРОЛ



МОНГОЛ ХЭЛ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:

Санамж:

- ✓ Монгол хэл, үндэсний бичиг, уран зохиолын 21 даалгаврыг 40 минутад гүйцэтгэх тул цагаа сайтар төлөвлөж бүх даалгаврыг ажиллаарай.
- ✓ Монгол хэлний даалгавруудыг гүйцэтгэхдээ эхийг уншиж, сайтар ойлгосон байхыг анхаараарай.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Гайхамшигт ургамал

Амьтан болбоос мэдэлтэй, ургамал болбоос мэдэлгүй бөлгөө. Тийн боловч ургамлын дотор амьтантай адил мэдэлтэй нь буй. Жишээлбэл, эвхмэл гэгч нэгэн зүйл өвсөнд гар хүрмэгц түүний навч нь агдайн*, салаа нь унжина. Гаднын бие хүрмэгц хариу үйлчлэл үзүүлж чадаж байгаа нь энэ өвсний ид.

Бас хортой барилт хэмээх өвс буй. Түүний навч үстэй, үсэнд нь наалдаатай шүүс буй тул батгана ялааны зүйлүүд түүний үсэнд буумагц даруй батгана ялааг идэх мэт эвхэж аваад, өдөржин байх ба өт хорхойн зүйл тэр өвсний “ходоодонд” орсон лугаа адил хайлж алга болдог байна.

Түүнчлэн исгэрдэг, шуугьдаг, шүгэлддэг, “ярьдаг” янз бүрийн дуу чимээ гаргадаг өвс ургамал буй. Ер ургамал бүхэн өөрийн гэсэн өнгө, үнэр, амттайн адил өөрийн гэсэн хэлтэй байдаг. Жишээ нь; монгол нутагт хаа сайгүй ургах цахилдаг гэж нэгэн зүйл ургамал цэцэглэхдээ исгэрэх, шуугих дуу гаргадаг ба түүний цэцэглэх дуунаар могой хуран цуглардаг. “Цаг цагаараа байдаггүй, цахилдаг хөхөөрөө байдаггүй” гэсэн хэлц үгэнд өгүүлдэг шиг цахилдгийн хөх цэцэг хагдарч унах үес эл дуу нь алга болж, могой ч холдож явдаг гэнэ.

Металл иддэг ургамал байдаг гэхэд та нар итгэх үү? Тэгвэл химийн найрлагатай хорт бодисоор бохирдсон хөрсийг цэвэрлэдэг, бас мөнгөн ус зэрэг химийн хүнд металлыг өөртөө авч шингээдэг гайхалтай ургамал ч байдаг гэнэ шүү. “Энэтхэг гич” нь бохирдсон хөрсийг цэвэрлэхдээ гойд аж. Гич хөрсөн дэх хүнд металлуудыг үндсэндээ бус навчиндаа хуримтлуулдаг гэнэ. Тиймээс хүнд металлыг агуулах болсон энэ ургамлын навчийг цуглуулан устгах нь зүйтэй.

Бас раскинс гэх ургамал нь хөрс, усыг хүнд болон цацраг идэвхт металлуудаас цэвэрлэх эдийн засгийн хамгийн шилдэг арга гэдгийг эрдэмтэд тогтоожээ. Түүнийг ашиглаж хөрсний хорт металлыг цэвэрлэх нь уламжлалт аргуудаас даруй 50-80 хувь давуу байгаа нь нотлогджээ.

Бидний бохирдуулсан ус, хөрс нь амьтдын нядалгааны газар болон хувирч байна. Үүнийг цэвэрлэх арга зам байгальд өөрт нь байдаг гэдгийн баталгаа нь эдгээр ургамлууд юм. Байгаль дээр ийм сонин амьдралтай, гайхамшигтай өвс ургамал өчнөөн олон. Заримыг нь эрдэмтэд нээж олоогүй, бас заримынх нь нууцыг тайлж чадаагүй байсаар байна. Гайхамшигт ургамал чамайг олж үзэхийг, бас танин мэдэхийг би хүснэм.

Д.Баттогтох “Зуун найман эсээ”

*агдайх-агшиж богино болох, охор болох

Монгол хэлний даалгаврууд

1. Эхийн 2-р цогцолборт барилт өвсний тухай өгүүлжээ. Тэгвэл 5-р цогцолборт юуны тухай өгүүлсэн бэ?
 - A. Мөнгөн ус зэрэг хүнд металлыг өөртөө шингээдэг ургамлын тухай
 - B. Байгаль дээр гайхамшигтай өвс ургамал байдаг тухай
 - C. Хөрс усыг цэвэрлэгч раскинс гэх ургамлын тухай
 - D. Исгэрдэг, шуугьдаг, шүгэлддэг, ярьдаг ургамал байдаг тухай



2. Эвхмэл гэгч өвсөнд гар хүрмэгц навч нь агдайн салаа нь унждагийн шалтгаан юу вэ?
- A. энэ өвс ид шидтэй учраас
 - B. гаднын бие хүрмэгц хариу үйлчлэл үзүүлж чаддаг учраас
 - C. өөрөө амьтан шиг мэдэлтэй учраас
 - D. түүний навч үстэй, үсэнд нь наалдаатай шүүс буй тул
3. Энэтхэг гичийн навчийг цуглуулан устгаснаар ямар үр дүн гарах боломжтой вэ?
- A. Мөнгөн ус зэрэг химийн хүнд металл үгүй болно.
 - B. Тухайн ургамал илүү өргөн хүрээг хамарч ургана.
 - C. Навч нь дахин ургах тул үндсээрээ устгагдах аюулаас аврагдана.
 - D. Химийн найрлагатай хорт бодисоор бохирдсон хөрс цэвэрлэгдэнэ.
4. Төгсгөлийн цогцолборын гол санааг олоорой.
- A. Бидний бохирдуулсан ус, хөрс нь амьтдын нядалгааны газар болон хувирч байна.
 - B. Эрдэмтэд учрыг нь нээж олоогүй, гайхамшигтай өвс ургамал өчнөөн олон бий.
 - C. Өөрийгөө цэвэрлэх арга зам байгальд өөрт нь байдаг.
 - D. Гайхамшигт ургамал чамайг олж үзэхийг, бас танин мэдэхийг би хүснэм.
5. Эхийн гол хэсэгт дуу чимээ гаргадаг өвс ургамлын талаар бичжээ. Энэ хэсгийн түлхүүр үгс аль вэ?
- A. дуу чимээ, өвс ургамал, цахилдаг, могой
 - B. дуу чимээ, өнгө, үнэр, амт, хөх цэцэг
 - C. исгэрэх, шуугих, шүгэлдэх, ярих, цугларах
 - D. монгол нутаг, хаа сайгүй, дуу алга болох
6. Дараах санаануудаас зохиолчийн үзэл бодлыг илэрхийлж буй нь аль вэ?
- A. “Цаг цагаараа байдаггүй, цахилдаг хөхөөрөө байдаггүй” гэсэн хэлц үгэнд өгүүлдэг шиг цахилдгийн хөх цэцэг хагдарч унах үес эл дуу нь алга болж, могой ч холдож явдаг гэнэ.
 - B. Гич хөрсөн дэх хүнд металлуудыг үндсэндээ бус навчиндаа хуримтлуулдаг гэнэ.
 - C. Түүнийг ашиглаж хөрсний хорт металлыг цэвэрлэх нь уламжлалт аргуудаас даруй 50-80 хувь давуу байгаа нь нотлогджээ.
 - D. Хүнд металлуудыг навчиндаа хуримтлуулдаг гич гэх ургамлын зөвхөн навчийг цуглуулан устгах нь зүйтэй.
7. Угсарсан нийлмэл холбоо үгийг олоорой.
- A. батгана ялаа
 - B. исгэрэх шуугих
 - C. химийн найрлага
 - D. дуу чимээ
8. “Гаднын бие хүрмэгц хариу үйлчлэл үзүүлж чадаж байгаа нь энэ өвсний ид” өгүүлбэрийн өнгө аясыг тодорхойлоорой.
- A. баталсан өнгө аястай
 - B. таамагласан өнгө аястай
 - C. үгүйсгэсэн өнгө аястай
 - D. бахархсан өнгө аястай
9. “Металл иддэг ургамал байдаг гэхэд та нар итгэх үү? Тэгвэл химийн найрлагатай хорт бодисоор бохирдсон хөрсийг цэвэрлэдэг гайхалтай ургамал ч байдаг гэнэ шүү” гэх хэсгийн “тэгвэл” хэмээх холбох үгийг солин найруулбал аль нь тохиромжтой вэ?
- A. Гэтэл
 - B. Тэгсэн ч
 - C. Тиймээс
 - D. Тухайлбал



10. “Гайхамшигт ургамал чамайг олж үзэхийг хүснэм” өгүүлбэрийг “цагийн утгаар” дэлгэрүүлсэн хэсэг аль вэ?

- A. Гайхамшигт ургамал чамайг нэг удаа олж үзэхийг хүснэм
- B. Гайхамшигт ургамал чамайг хурдхан олж үзэхийг хүснэм
- C. Гайхамшигт ургамал чамайг одоо л олж үзэхийг хүснэм
- D. Гайхамшигт сонин ургамал чамайг олж үзэхийг хүснэм

11. Аль өгүүлбэрт анхаарлын тэмдэг (!) тавих вэ?

- A. Та сайхан хооллоорой
- B. Хүү минь, гарч тогло
- C. Үндэсний бичгээ уншаач
- D. Хүүхдүүд ээ хичээлээ хий

Үндэсний бичгийн даалгаврууд

12. “ ” бийрээр бичсэн өгүүлбэрийг зөв уншаарай.

- A. Гол гэмээн боо цуг
- B. Хулан хэмээн буу зэх
- C. Голон хэлэн бүү зөө
- D. Хол хэмээн бүү цөх

13. “гүүр” хэмээх үгийг зөв бичсэнийг олоорой.

- | | | | |
|----|----|----|----|
| A. | B. | C. | D. |
| | | | |

14. “ ” буюу гууль” хэмээх үгтэй ижил хэлбэрээр бичих үгийг олоорой.

- | | | | |
|----|----|----|----|
| A. | B. | C. | D. |
| | | | |

15. “сонус+гчи” бүтээврийн нийлцийг зөв бичсэнийг олоорой.

- | | | | |
|----|----|----|----|
| A. | B. | C. | D. |
| | | | |

16. “” хэмээх үгэнд холбох эгшгийн дүрмээр шууд залган бичих нөхцөлийг олоорой.

А.

В.

С.

D.

Уран зохиолын даалгаврууд

17. “Цогт тайжийн хадны бичиг” зохиолын доорх бадагт уран дүрслэлийн ямар арга илэрч байна вэ?

Хол ойроос хулгай хийгч хүмүүн хийгээд

Хотыг эргэн гэтэгч чоно хоёрын

Илт бие дүр өөр болбоос

Идэхүйг хүсэх сэтгэлийн агаар нэгэн буй

A. ихэсгэл

B. тойруулал

C. багасгал

D. адилтгал

18. “Цогт тайжийн хадны бичиг” зохиолын

Энэ биедээ эс золголцвоос

Үүнээс хойд төрөл тутамдаа

Эх нь ганц хүүхнээ хайрлах мэт

Элдэв үйлээр туслалцах болтугай гэсэн бадагт ямар санааг агуулж байна вэ?

A. Энэ жилдээ золгож чадахгүй, ирэх жилээс очиж золгоно гэсэн санаа

B. Энэ насандаа заавал очиж золгон, элдэв үйлээр тусална гэсэн санаа

C. Хойд насандаа эх охин хоёр болж, бие биесээ хайрлан халамжлах санаа

D. Алс газраас бие биеэ санагалзан дурсаж, үгүйлэн суух нь сайхан гэсэн санаа

19. “Чингисийн эр хоёр загалын тууж оршив” зохиолд хэсэгт “Бага загал нь Их загалаас:

Өвсийг эрүүгээр иддэг байтал

Усыг уруулаар уудаг байтал

Авгай, арьстай шөрмөстэй хатах чинь

Юу буй” хэмээн асуудаг. Тэгвэл их загалын турсан шалтгаан юу вэ?

A. их загал бага загал дүүдээ гомдон, арьс шөрмөс нь хатсан болохоор

B. их загал төрсөн нутаг, гэр бүлээ санагалзсанаас турсан болохоор

C. өвс идэж, ус ууж чадахааргүй болтлоо өвдсөн болохоор

D. эзэн богд чингис хааны аян дайнд яваад туйлдаж ядарсан болохоор

20. Д.Нямсүрэн “Дөрвөн цаг” шүлгийн дараах бадгийн сүүл холбоцыг зөв тодорхойлоорой.

Сартай толгодод ингэ гунганах сайхан

Шанзны үзүүрт Ай-нан-аа суух сайхан

Шаргал дөл угалзлан гал ноцох нь сайхан

Царай зүс бүдэг бадаг гэрэлтэх нь сайхан

A. салаалсан холбоц

B. хашсан холбоц

C. хос холбоц

D. бүрэн холбоц

Санамж:

- ✓ Хоёрдугаар хэсэг харгалзуулах даалгавар тул хариултын хуудасны 2-р хэсэгт зааврын дагуу будаж тэмдэглээрэй.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Эхийг уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

Нэгэн бүсгүй 39 настайдаа нөхрийнхөө зохион бүтээсэн шинэ машиныг бариад, хоёр хүүхдээ суулган, Манхаймаас 90 км гаран зайд байх Порцхайм хотод суугаа ээж рүүгээ явжээ. Тэнд очингуутаа нөхөртөө “Бид эмээгийнд ирлээ, бүх зүйл сайн” гэсэн цахилгаан илгээжээ. Нөхөр нь айсан залхуурсны алиныг бүү мэд, өөрийн бүтээсэн машиныг шалгаж үзэлгүй хоёр жил болсон байжээ. Нөхрийг нь Карл Бенц гэдэг байв. Харин 1888 онд, 96 км замаар зориглон давхисан эмэгтэйг Берта Бенц гэдэг байжээ.

Тухайн үед модон дугуйтай 4 араатай, 2 литрийн мотортой хоёр дугуйтаар 12 цаг үсчин явсан гэхээр их зоригтой эмэгтэй байсан байх гэж бодогддог. Магадгүй тийм ч учраас зорьсноо биелүүлж чадсан байх.

Benz Motorwagen No 3 машиныг аюулгүй хэрэглэж болох нь ийнхүү батлагдсанд Карл ажлаа үргэлжлүүлэх урам зоригтой болсон гэдэг. Бүсгүй дараа нь охин төрүүлж, Мерседес гэж нэрлэсэн бөгөөд цаашаа юу болсныг та бүхэн мэднэ.

Берта бол машинаар замд явсан дэлхийн анхны хүн.

2.1. Дараах өгүүлбэрүүдийг тохирох баримттай нь зөв харгалзуулаарай. Нэг баримтад хэдэн ч өгүүлбэр багтаж болох ба зарим баримтад харгалзах жишээ байхгүй ч байж болно.

- | | |
|---|-------------------------------|
| a. Харин 1888 онд, 96 км замаар зориглон давхисан эмэгтэйг Берта Бенц гэдэг байжээ. | 1. таамагласан баримт |
| b. Магадгүй тийм ч учраас зорьсноо биелүүлж чадсан байх. | 2. учир шалтгааны баримт |
| c. Тэнд очингуутаа нөхөртөө “Бид эмээгийнд ирлээ, бүх зүйл сайн” гэсэн цахилгаан илгээжээ. | 3. мэдээлэл лавлагааны баримт |
| d. Бүсгүй дараа нь охин төрүүлж, Мерседес гэж нэрлэсэн бөгөөд цаашаа юу болсныг та бүхэн мэднэ. | 4. тоон баримт |
| e. Берта бол машинаар замд явсан дэлхийн анхны хүн. | |